



СУХБААТАР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 05

Баруун-Урт сум

“Цахим Сүхбаатар” дэд хөтөлбөр
батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг, дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3, 21 дүгээр зүйлийн 21.1.15, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, 60 дугаар зүйлийн 60.1.8, Харилцаа холбооны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит Хорин гуравдугаар Хурлаас ТОГТООХ нь:

1.“Цахим Сүхбаатар” дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, шаардагдах зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган шийдвэрлэхийг аймгийн Засаг дарга (М.Идэрбат)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (А.Чулуунбат)-д даалгасугай.



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 04 сарын 19-ний өдрийн
05 тоот тогтоолын хавсралт

“ЦАХИМ СҮХБААТАР” ДЭД ХӨТӨЛБӨР

1. Хөтөлбөрийн үндэслэл:

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Цахим-Монгол” төрийн шуурхай үйлчилгээ, Засгийн газрын 2017 оны 47 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого-2025”-ын 2.3.8-д заасан “Төрийн байгууллагын үйл ажиллагааны бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, засаглалын ардчилсан, нээлттэй, хүнд сурталгүй, ил тод, хариуцлагатай байдлыг идэвхжүүлэн, төрийн үйл ажиллагааны инновациг дэмжиж, цахим засгийн хөгжлийг боловсронгуй болгох замаар цахим засаглалыг хөгжүүлнэ” гэсэн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан цахим хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд “Сүхбаатар аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Цахим Сүхбаатар” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг албан тушаалтын хамаарлыг багасгаж, шуурхай, хүртээмжтэй, хүнд сурталгүй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, хөрөнгө зардлыг хэмнэнэ гэсэн зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

2. Аймгийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын өнөөгийн байдал

Сүхбаатар аймгийн хэмжээнд 13 сум, суурин газрыг холбосон 1093,34 км үндсэн сүлжээний шилэн кабельд холбогдсон. Уг шилэн кабелиар өгөгдлийн (Data, MPLS-VPN) болон тоон сувгийн (E1, STM, TDM) үйлчилгээ, олон улсын интернетийн бөөний урсгалын үйлчилгээг үзүүлж байна.

Одоогоор Асгат, Халzan, Баяндэлгэр, Онгон, Сүхбаатар, Эрдэнэцагаан сумдыг 10G сүлжээнд 2022-2023 онд холболт хийж 10 дахин өсгөж хувийн болон төрийн байгуулгуудад өндөр хурдны сүлжээ дамжуулхад боломжийг бүрдүүлээд байна. Хот хоорондын үндсэн сүлжээг 100G болгон өргөтгөж найдвартай ажиллагааг ханган ажиллаж байна.

Аймгийн төвийн төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг шилэн кабельд холбох ажлын хүрээнд 2013 оноос эхлэн ажиллаж одоогоор 95 орчим хувьтай байгаа ба үлдсэн 5% нь радио линк ашиглаж байна.

Баруун-Урт сумын хэмжээнд давхардсан тоогоор 9000м орчим шилэн кабель тархааж, Сүхбаатар аймгийн хэмжээнд 13 сумын 66 багаас 52 баг нь багийн төвтэй бөгөөд үүнээс 50%-д нь дөнгөж оператор компаниудын 3G болон 4G сүлжээ нэвтэрч ард иргэд ашиглаж байна.

Эрүүл мэндийн салбарын хувьд эмнэлгийн байгууллагууд хоорондоо “<https://www.health.gov.mn>” цахим системийг ашиглан үйлчлүүлэгчдэд үзлэг,

шинжилгээ, хэвтэн эмчлүүлэгчдийн бүртгэл хөтлөлтийг хийж, эмийн хөнгөлөлтийн мэдээллийг эмийн сангудтай шууд солилцож байна.

Боловсролын салбарт "<https://www.esis.edu.mn/>" платформоор дамжуулан төлөвлөгөө, тайлан гаргах, сургачдын бүртгэл, дүн нэгтгэл, цахим сургалтын контент, эцэг эхийн систем, хоол бүртгэлийн систем, хөдөө аж ахуйн салбарт мал бүртгэлийн нэгдсэн систем, хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн мэдээллийг бүртгэх систем, байгаль орчны салбарт "Байгаль орчны мэдээллийн нэгдсэн сан" систем, онцгой байдлын салбарт "Гамшиг, ослын байршил мэдээллийн нэгдсэн сан", Барилга хот байгуулалтын чиглэлээр "Газар зохион байгуулалтын цахим систем"-үүд тус тус ашиглаж байна. Нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйлчилгээ бүрэн цахимжсан. Эрчим хүч, ус, халаалт дулааны төлбөр тооцоог иргэн цахим хэлбэрээр төлөх, аймгийн төв, сумдын гэр хороололд ухаалаг худгийн үйлчилгээг нэвтрүүлж, соёлын салбарт нийтийн цахим номын сангийн системтэй болсон.

Төрийн байгууллагын үйл ажиллагаанд "төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны нэгдсэн систем" (Egr.e-mongolia.mn), "төрийн үйлчилгээний нэгдсэн систем" (e-mongolia.mn), "бизнес эрхлэгчдэд зориулсан" (e-business.mn), "хяналт шинжилгээ, үнэлгээний нэгдсэн систем", "төрийн байгууллагын цахим хуудас, цахим шуудангийн үйлчилгээ", "төрийн албаны шалгалтын систем", "үндэсний судалгааны нэгдсэн систем" ([https://sudalgaa.gov.mn/](http://sudalgaa.gov.mn)), "санхүүгийн төлбөр, тооцооны цахим системүүд", "төрийн шагналын систем" ([https://able.mn/](http://able.mn)), "Орон нутгийн хөгжлийн индекс" (<http://ldi.nda.gov.mn>) системүүд нэвтрүүлсэн байна.

Цахим гарын үсгийн тухай хууль 2022 оны 5 дугаар сарын 01-нээс хэрэгжиж эхэлснээс хойш иргэн болон албан тушаалтныг тоон гарын үсэгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн. Ингэснээр төрийн байгууллагын үйл ажиллагаанд тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг иргэд тоон гарын үсгээ ашиглан авах арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулж байна.

3. Хөтөлбөрийн зорилго:

Эдийн засгийн шинэ орчин, оюунлаг чадавхыг бий болгох, аймгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тогтвортой хөгжлийг хангах замаар хүн амын амьдралын чанарыг сайжруулж, Мэдээлэл, харилцаа холбооны орчин үеийн технологи, цахим мэдээлэл солилцооны нэгдсэн системийг төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд нэвтрүүлж, бизнесийн хөгжлийг дэмжих, бүх салбарын инновацыг тэтгэх, ажлын бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх замаар төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, хурдан шуурхай, хүнд сурталгүй, шударга, ил тод нээлттэй /цахим/ засаглалыг төлөвшүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

4. Хөтөлбөрийн зорилт:

- 4.1 Аймгийн Хэмжээнд харилцаа холбоо, мэдээлэл технологийн салбарын дэд бүтцийг нэмэгдүүлэх
- 4.2 Төр, иргэн, аж ахуй нэгжийн гурвалсан түншлэл бүхий иргэн төвтэй төрийн цахим үйлчилгээг бүрдүүлэх
- 4.3 Харилцаа холбоо мэдээллийн технологийн салбарын инженер техникийн ажилтан /ИТА/ хүний нөөцийг хөгжүүлж, иргэдийн цахим оролцоо түүний ур чадварыг нэмэгдүүлж цахим соёлыг хэвшүүлэх

4.4 Иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх

5. Хэрэгжүүлэх арга хэмжээ, үр дүн

5.1. Хөтөлбөрийн хэрэгжих хугацаа: 2024-2026

6. Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ, гарах үр дүн:

6.1. Аймгийн Хэмжээнд харилцаа холбоо, мэдээлэл технологийн салбарын дэд бүтцийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

6.1.1. Суурь сүлжээнд тулгуурлан IP протоколд суурилсан харилцаа холбоо, мэдээлэл технологийн дэд бүтцийг нэмэгдүүлэх

6.1.2.Өндөр хурдны шилэн кабелийн үл тасалдах интернэтийн сүлжээг бий болгох

6.1.3.Төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын сүлжээний тоног төхөөрөмж, программ хангамжийг шинэчлэн сайжруулж интернэтийн хурдыг нэмэгдүүлэх

6.1.4. Хил, гааль, боомт, аялал жуулчлал, амралт зугаалгын бүсүүдэд үнэгүй WIFI бүс, орчин бүрдүүлэх

6.2. Төр, иргэн, аж ахуй нэгжийн гурвалсан түншлэл бүхий иргэн төвтэй төрийн цахим үйлчилгээг бүрдүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

6.2.1.Орон нутгийн удирдлагыг бодит мэдээллээр хангасан оновчтой шуурхай шийдвэр гаргахад чиглэсэн байгууллагуудын мэдээллийг нэгтгэсэн "Сүхбаатар-дашбоард" нэвтрүүлэх

6.2.2.Иргэд болон жуулчдад зориулсан аймгийн үйлдвэрлэл, үйлчилгээ, соёл урлаг, эмийн сан, нийтийн болон орон нутгийн тээвэр, зар мэдээлэл зэргийг багтаасан иргэдийн гар утасны апп нэвтрүүлэх

6.2.3.Сумдын ЗДТГ болон албад агентлагийн үзүүлж буй төрийн үйлчилгээнд суурь судалгаа хийж шаардлагатай үйлчилгээнүүдийг E-Mongolia Төрийн мэдээллийн нэгдсэн системд холбох ажлыг хийж гүйцэтгэх, дахин загварчлах

6.2.4.Төрийн албан хаагчдад цахим шилжилтийн талаар мэдлэг, ур чадвар олгох сургалт арга хэмжээг үе шаттайгаар тасралтгүй зохион байгуулах

6.2.5.Аймгийн хэмжээнд тоон гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлэх, ашиглалтыг нэмэгдүүлэх

6.2.6.Сумдад Төрийн цахим үйлчилгээний ТҮЦ болон ХУРДАН цэгийг байгуулах ажлыг үе шаттай зохион байгуулах

6.2.7.Иргэд өөртөө үйлчлэх ухаалаг (24/7) төвийг бий болгох

6.2.8.Сум, албад агентлагуудад архивын цахим программ нэвтрүүлж байнга хадгалах баримтын цахим архив үүсгэх ажлыг гүйцэтгэж, хадгалалт хамгаалалтыг стандартын дагуу хийж, хяналт тавих

6.2.9.Төрийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажлыг эрчимжүүлэх, төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах

6.3. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аюулгүй байдлыг хангах, салбарын инженер техникийн ажилтан /ИТА/ хүний нөөцийг хөгжүүлж,

иргэдийн цахим оролцоо түүний ур чадварыг нэмэгдүүлж, цахим соёлыг хэвшүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

- Аймгийн ЗДТГазрын дэргэдэх мэдээлэл технологийн албаны чадавх, орон тоог нэмэгдүүлэх

6.3.1. Төрийн байгууллагууд “Мэдээллийн аюулгүй байдлын нийтлэг журам”-ын хүрээнд дотооддоо журам боловсруулж, мөрдөн ажиллах

6.3.2. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр байгууллага бүр хэрэглээний болон вирусийн эсрэг лицензтэй программ хангамжийг хэрэглэх

6.3.3. Мэдээлэл, технологийн парк, ХАБ байгуулж, гарааны компанийг дэмжих

6.3.4. Харилцаа, холбоо, мэдээлэл, технологийн салбарын албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг үе шаттай зохион байгуулах

6.3.5. Ерөнхий боловсролын сургуульд мэдээлэл технологийн секц, дугуйлан хичээллүүлж сургачдыг инженер техникийн боловсрол эзэмшүүлэхэд бэлтгэх

6.3.6. Мэдээлэл, технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй сайн дурын бүлэг, клуб, холбоодын үйл ажиллагааг дэмжих

6.3.7. Иргэд, зорилтот бүлгийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг аймгийн ТЦҮХэлтэс, Насан туршийн боловсрол олгох төвийг түшиглэх тасралтгүй зохион байгуулах

6.4. Иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

6.4.1. Аймаг, сумын төвийн камержуулалтыг нэмэгдүүлж, нэгдсэн хяналтын системийг сайжруулах

6.4.2. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх, шийдвэрлэлтийн явцад хяналт тавих үйл ажиллагааг цахимжуулах

6.4.4. Иргэдийн хаягийн нэгдсэн системийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах

6.4.5. EKIDS хүүхэд хамгааллын системийг аймгийн хэмжээнд бүрэн нэвтрүүлэх

6.4.6. “Ухаалаг худаг” системийг орон нутагт нэвтрүүлэх

7. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

7.1 Орон нутагт ил тод, иргэн төвтэй, хариуцлагатай, өндөр бүтээмжтэй засаглалыг бэхжүүлэх;

7.2 Цахим засаглалын бодлого, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах;

7.3 Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах;

7.4 Ногоон технологийг дэмжих

7.5 Эдийн засгийн өсөлтийг хангахад чиглэсэн шинэ чадавхыг бий болгох зорилгоор аялал жуулчлалын болон мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил дэвшлийг нэвтрүүлэх

8. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн бодлого, удирдамжаар хангах ажлыг аймгийн засаг даргын тамгын газар, аймаг дахь төрийн цахим үйлчилгээний хэлтэс хариуцан зохион байгуулах бөгөөд хамтран хэрэгжүүлэх, биелэлтийг нэгтгэн тооцох үргийг хүлээнэ.

Төрийн болон төрийн өмчит байгууллагууд нь технологийн дэвшил ухаалаг шийдлүүдийг нэвтрүүлж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэн, үйлчилгээний чанар хүртээмж, шуурхай байдлыг хангаж ажиллана.

Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн засаг даргаар

батлуулан хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг цахим шилжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийн дагуу Хяналт шинжилгээ үнэлгээ хийж аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд танилцуулж, үр дүнг тооцно.

9.Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр улс, орон нутгийн төсвийн санхүүжилт болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлнэ. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгө
Орон нутгийн төсвийн хөрөнгө
Олон улсын байгууллагын зээл, тусlamж
Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
Бусад эх үүсвэр

10.Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн:

- 10.1 Иргэн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр хүргэх төрийн үйлчилгээний тоо, чанар, хүртээмж нэмэгдэнэ.
- 10.2 Төрийн болон Нутгийн захиргааны байгууллагуудын интернэтийн хурд сайжирч, цахим хурал, зөвлөгөөн, сургалт, семинар, хэлэлцүүлэг зэрэг аливаа арга хэмжээг өргөтгөсөн хэлбэрээр шуурхай зохион байгуулах боломж бүрдсэн байна.
- 10.3 Аймгийн хэмжээнд egr.e-mongolia.mn төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем нэвтрүүлснээр байгууллага, албан хаагчдын баримт бичиг, мэдээллийг шуурхай солилцох нөхцөл бүрдэж, ажлын бүтээмж болон цахим баримт бичгийн эргэлт сайжирч, бичиг хэргийн болон шуудангийн зардлыг бууруулсан байна.
- 10.4 Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал сайжирна.
- 10.5 Төрийн албан хаагчдыг сургалтад хамруулах замаар мэдлэг боловсролыг нь дээшлүүлснээр чадварлаг, мэргэшсэн хүний нөөц бүрдэнэ.
- 10.6 Төрийн бодлого, шийдвэр гаргах үйл явцад иргэд цахим хэлбэрээр оролцох боломж нэмэгдэж, үйл ажиллагааны ил тод, шуурхай байдал нэмэгдэнэ.
- 10.7 Сум, байгууллагууд байнга хадгалах баримтын цахим архивыг цаг тухайд нь үүсгэж, байгууллагын архивд цахим архивын сан бий болсон байна.
- 10.8 Төрийн албан хаагчдын цахим албан хэрэг хөтлөх, дотоод удирдлагын систем ашиглахтай холбоотой чиг үүргийг “Албан тушаалын тодорхойлолт”-д нь тусган төрийн албан хаагч бүр дотоод удирдлагын системийг тогтмол ашиглаж, албан бичгийг цахимаар солилцож хэвшсэн байна.

11. Хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт үнэлгээ, тайлагналт:

11.1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ба шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж болно.

11.1.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан Засаг даргад танилцуулж, аймгийн ИТХ-д уламжилна.

12. Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2023 он)	Зорилтот түвшин (2026 он)	Хариуцагч талууд
1	Төрийн байгууллагын интернэт сүлжээний хурдыг нэмэгдүүлэх	20 мегабайт	50 мегабайт	Сумд, агентлаг албад
2	Интернэтийн хурд нэмэгдүүлсэн байгууллагын тоо	-	60	Бүх шатны төрийн байгууллага
3	Утасгүй интернэт бүсийн байршлын тоо	-	7	МХС, МЦХ, үүрэн телефоны оператор компаниуд, хувийн хэвшил
4	Удирдлагын шийдвэр гаргалтад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байдал	-	Систем нэвтрүүлсэн байна.	АЗДТГ, ТЦҮХ
5	Цахимжуулсан төрийн үйлчилгээний тоо	73	154	АЗДТГ, ТЦҮХ, И-Монгол академи
6	“Хурдан” цэгийн үйлчилгээг нэвтрүүлсэн цэгийн тоо	3	16	АЗДТГ, ТЦҮХ, Сумдын ЗДТГазар
7	Төрийн үйлчилгээний нэгдсэн төвөөр үйлчлүүлсэн иргэдийн тоо	5150	15000	АЗДТГ, ТЦҮХ, Сумдын ЗДТГазар
8	Иргэдийн “Цахим ур чадвар дээшлүүлэх” чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо	30	140	АЗДТГ, ТЦҮХ, Сумдын ЗДТГазар, НТБТөв
9	“Цахим ур чадвар олгох” сургалтад хамрагдсан иргэдийн тоо	1500	10000	АЗДТГ, ТЦҮХ, Сумдын ЗДТГазар, НТБТөв
10	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийн хувь	75	90	Агентлаг, төсөвт байгууллага, сумдын ЗДТГазар
11	Мэдээллийн аюулгүй байдлын журамтай болсон байгууллагын тоо	5	60	Агентлаг, төсөвт байгууллага, сумдын ЗДТГазар
12	Хэрэглээний болон вирусын эсрэг албан ёсны эрхтэй программ хангамжтай байгууллагын тоо	-	60	Агентлаг, төсөвт байгууллага, сумдын ЗДТГазар
13	Камержуулалтын нэгдсэн системд холбогдсон албан	208	200	Агентлаг, төсөвт байгууллага,

	байгууллага, аж ахуй нэгжийн тоо, хувиар			сумдын ЗДТГазар
14	Төрийн байгууллагууд иргэдээс цахимаар хүлээн авч шийдвэрлэсэн санал, хүсэлт, өргөдөл гомдлын хувь	-	40-с доошгүй хувь	Агентлаг, төсөвт байгууллага, сумдын ЗДТГазар
15	Иргэдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл гомдлыг үндэслэн авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	-	20	Агентлаг, төсөвт байгууллага, сумдын ЗДТГазар
16	Ekids системийн ашиглалт хэрэглээний талаар иргэдэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулсан тоо	-	15	Агентлаг, төсөвт байгууллага, сумдын ЗДТГазар
17	Орон нутгийн байгууллагууд цахим шилжилтийн чиглэлээр зохион байгуулж, хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	-	30	Агентлаг, төсөвт байгууллага, сумдын ЗДТГазар